



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№50**

Төсөвт өртөг: 2,400,000 төгрөг

2026.03.04

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	“Анхны тусламжийн сургалт”	багц	1.0	Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Байгууллагын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, гэмтэл, гэнэтийн өвчлөл, амь насанд аюултай нөхцөл байдал үүссэн үед анхны тусламжийг стандартын дагуу шуурхай, зөв аргачлалаар үзүүлэх мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшүүлэх, ослын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-иас шууд худалдан авалтаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх тухай ажлын даалгавар

1. Ерөнхий мэдээлэл

Захиалагч байгууллага: ДТҮ ХХК

Бараа, ажил, үйлчилгээний нэр: “Анхны тусламжийн сургалт”

Төсөвт өртөг: 2,400,000 (Хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөг

Худалдан авах ажиллагааны арга: Шууд худалдан авалт

2. Худалдан авах үйлчилгээний зорилго

Байгууллагын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, гэмтэл, гэнэтийн өвчлөл, амь насанд аюултай нөхцөл байдал үүссэн үед анхны тусламжийг стандартын дагуу шуурхай, зөв аргачлалаар үзүүлэх мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшүүлэх, ослын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

3. Сургалтын хамрах хүрээ, зохион байгуулалт

- Нийт хамрагдах ажилтан: **100 ажилтан**
- Сургалтыг **3 ээлжээр** (хуваан) зохион байгуулна.
- Сургалтыг танхимаар зохион байгуулна.
- Сургалтын үйлчилгээ үзүүлэгч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн анхны тусламжийн стандарт, аргачлалд нийцсэн сургалтын хөтөлбөр, баталгаажсан сургагч багштай байна.

4. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага ба бүрдүүлэх материал

Сургалтын үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй байх
- Холбогдох чиглэлээр сургалт явуулах **тусгай зөвшөөрөлтэй** байх
- Сургагч багш нь тухайн чиглэлээр **мэргэжлийн болон багшлах эрхийн гэрчилгээтэй** байх
- Ижил төстэй сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх
- Үнийн санал (албан бичгээр, байгууллагын гарын үсэг, тамгатай)

5. Төлбөрийн нөхцөл

- Урьдчилгаа төлбөр олгохгүй.
- Гэрээт ажлын төлбөр болох **100 хувь буюу 2,400,000 төгрөгийг** сургалтын байгууллага гэрээний дагуу бүх ажлыг бүрэн гүйцэтгэж, талууд ажлыг актаар хүлээлцсэний дараа, гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

6. Гүйцэтгэх хугацаа

- Гэрээ батлагдсаны дараа гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцож тогтооно.
- Захиалагч талаас сургалтын товыг урьдчилан мэдэгдэнэ.
- Гүйцэтгэгч нь товлосон хугацаанд сургалтыг зохион байгуулна.
- Гүйцэтгэх хугацааг тооцохдоо **хуанлийн өдрийг** баримтална.

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044